

ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 4-р сарын 07-ны өдөр

№1

Улаанбаатар хот

Тооллогын
дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт болон Компанийн дүрэм, 2023 оны 04-р сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Гермес Центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 43 801 120 саналын эрхтэй 5 хувьцаа эзэмшигч, мөн хуралд биечлэн оролцож байгаа 24 221 646 саналын эрхтэй 15 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул тооллогын дүнг хавсралтын дагуу баталж, ээлжит хурлын дарга (Д.Оюунсүрэн)-д танилцуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

О. Энхжаргал

О.ЭНХЖАРГАЛ

Л. Оюунгэрэл

Л.ОЮУНГЭРЭЛ

Д. Отгончимэг

Д.ОТГОНЧИМЭГ



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20²³ оны 04 сарын 07 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Тооллогын
дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, Компанийн дүрэм, 2023 оны 04-р сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй 86.61 хувийн хувьцаа эзэмшигчид (хавсралт №1) хүрэлцэн ирсэн тул хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцугай.
2. Хурлын ирц хангалттай тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.



ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар ... 02

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 8.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Гермес Центр” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2023 оны 04-р сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн өгсөн дүгнэлтийг хавсралтын дагуу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАНД ТУЗ-ӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Гермес Центр” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудын хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Компанийн ТУЗ нь 2021 оны 12-р сарын 22-ны өдөр компанийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Улмаар гүйцэтгэх удирдлагын баг нь батлагдсан төсөв төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

“Гермес Центр” ХКомпани нь 2022 онд 1 245.1 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. Ашгийн төлөвлөгөө 1 161.6 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 107 %-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 83.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн.

2022 онд нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ 15 төгрөг 85 мөнгө гарсан. 2022 оны нэгж хувьцаанд ногдох ашгийн төлөвлөгөө 14 төгрөг 79 мөнгө байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 107 %-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 1 төгрөг 06 мөнгөөр давуулан биелүүлсэн болно.

Иймээс тус компанийн гүйцэтгэх удирдлагын багийг 2022 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай САЙН ажилласан хэмээн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж байна.

ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20²³ оны 04 сарын 07 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

ТУЗ-ийн
төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 8.7 дахь заалт, 2023 оны 04-р сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулахыг ТУЗ-ийн дарга (Д.Оюунсүрэн)-д зөвшөөрсүгэй.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН